

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн
/9. дугаар тогтоолын Хоёрдугаар хавсралт

УХАД 0163

* ТУЗ *

УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АРИЛЖААНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь “Монголын хөрөнгийн бирж” ХК /цаашид “Бирж” гэх/ дээр явагдаж буй уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжааны хяналтыг хэрэгжүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцогч, брокерийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, зохих шалгалтыг хийх, шалгалтын дүнгээр авах арга хэмжээг хэрэгжүүлэх, хариуцлага ногдуулах зэрэг харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Биржийн уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжаатай холбоотой үйл ажиллагаа нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ болон Биржээс баталсан журам, заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэрийн хүрээнд хэрэгжинэ.
- 1.3. Биржийн хяналт шалгалтын үйл ажиллагаа нь хууль тогтоомж, Биржийн эрх бүхий ажбан тушаалтнаас баталсан журам заавар, түүнд нийцүүлэн гаргасан бусад шийдвэрийн хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцогчдын үүргийн биелэлтийг хангахад чиглэнэ.
- 1.4. Хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэ журам болон Хороо, Биржээс баталсан бусад журам, удирдамж, зааврыг удирдлага болгоно.
- 1.5. Энэ журамд орох нэмэлт өөрчлөлтийг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ баталж, Хороо батламжилна.

ХОЁР. ЖУРАМД ОРСОН НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1. Энэхүү журамд тусгагдсан нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1. "Биржийн арилжаанд оролцогч" гэж Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 4.1.2-т заасныг;
 - 2.1.2. "Худалдагч тал" гэж Биржийн тусгай програмаар дамжуулан уул уурхайн бүтээгдэхүүнийг нээлттэй цахим арилжаагаар худалдаж буй талыг;
 - 2.1.3. "Худалдан авагч тал" гэж Биржийн тусгай програмаар дамжуулан уул уурхайн бүтээгдэхүүнийг нээлттэй цахим арилжаагаар худалдан авч буй талыг;
 - 2.1.4. "Биржийн арилжааны зуучлагч /брокер/" гэж Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 4.1.3-т заасныг;

- 2.1.5. “Төлөвлөгөөт шалгалт” гэж гүйцэтгэх удирдлагаас баталсан удирдамжийн дагуу хоёр жил тутам хийгдэх шалгалтыг;
- 2.1.6. “Төлөвлөгөөт бус шалгалт” гэж эрх бүхий этгээдийн хүсэлт, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, арилжаа хянах явцад илэрсэн зөрчил зэрэг бусад шаардлагаар биржийн арилжаанд оролцогчид урьдчилан мэдэгдэлгүйгээр хийх шалгалтыг;
- 2.1.7. “Эрсдэл бүхий хэлцэл” гэж биржээр арилжаалагдаж буй уул уурхайн бүтээгдэхүүний үнэ ханшийн хэлбэлзэл, арилжигдсан тоо ширхэг зэргийг үндэслэн Хяналт шалгалт хариуцсан нэгжээс тодорхойлсон эрсдэлтэй байж болзошгүй хэлцлийг.

ГУРАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1. Хяналт шалгалт хариуцсан нэгж нь уул уурхайн бүтээгдэхүүний цахим арилжааны хяналтыг холбогдох програмаар болон газар дээрх гэсэн хэлбэрээр хийнэ.
- 3.2. Өдөр тутмын хяналтыг арилжааны явцад холбогдох програм хангамж ашиглан хэрэгжүүлнэ.
- 3.3. Өдөр тутмын хяналт хэрэгжүүлэх явцад эрсдэл бүхий хэлцэл илэрсэн тохиолдолд нарийвчилсан шалгалт явуулна.
- 3.4. Газар дээрх хяналтыг гүйцэтгэх захирлаас баталсан удирдамж, эрсдлийн төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус байдлаар явуулна.
 - 3.4.1 Төлөвлөгөөт хяналт шалгалт нь тогтоосон хуваарь, төлөвлөсөн цаг хугацаанд батлагдсан удирдамж, эрсдлийн төлөвлөгөөний дагуу газар дээр нь очиж хийх шалгалт;
 - 3.4.2 Төлөвлөгөөт бус шалгалт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ёргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэр, арилжаа хянах явцад илэрсэн зөрчлийн дагуу газар дээр нь очиж хийх шалгалт;
- 3.5. Хяналт шалгалт хариуцсан нэгж нь хяналт шалгалтын явцад дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:
 - 3.5.1. Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаатай холбоотой баримт материалтай танилцах, хуулбарлах, холбогдох этгээдээс гаргуулан авах;
 - 3.5.2. Арилжаанд оролцогчдоос тайлбар авах, нотлох баримт гаргуулах (Шалгалтын ажлын нотлох баримтад зөрчлийн үнэн бодит байдлыг нотлохуйц бүх баримт материал, холбогдох талуудын болон гуравдагч этгээдийн тайлбар, шалгалтын ажлын дүгнэлт, дуу дүрсний бичлэг, цахим мэдээлэл зэрэг багтах бөгөөд нотлох баримт нь үнэн зөв, нотлох баримтын шаардлага хангахуйц байна);
 - 3.5.3. Хяналт шалгалтын явцад шалгагдаж буй этгээдээс тайлбар авч буй тохиолдолд тэмдэглэл үйлдэн, гарын үсэг зурж баталгаажуулах, шалгагдаж буй этгээд гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд хяналт шалгалтын мэргэжилтэн шалтгааныг тодруулж тэмдэглэлд тусгах;
 - 3.5.4. Хяналт шалгалтын мэргэжилтэн нотлох баримт материал, дуу дүрсний бичлэг, цахим мэдээлэл зэргийг цуглуулах бүрт бүртгэл үйлдэж, нотлох баримтыг цуглуулсан цаг, газрыг тэмдэглэн, гарын үсэг зурж баталгаажуулах;

3.5.5. Аливаа зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах.

3.6. Шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох тайланг Хороонд хүргүүлнэ.

3.7. Биржийн арилжаанд оролцогч болон Биржийн хяналт шалгалтын мэргэжилтэн нь шалгалтын явцад олж мэдсэн мэдээллийн нууцлалыг чанд хадгална.

3.8. Бирж нь хяналт шалгалт явуулахдаа бусдаас урамшуулал, мөнгөн шагнал, шан харамж авахыг хориглох бөгөөд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

ДӨРӨВ. ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Биржийн арилжаанд оролцогч дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно. Үүнд:

4.1.1. Арилжаанд оролцогч бусад этгээдийн нэр хүндийг гутаах, эсхүл өрсөлдөгчөө алдагдалд оруулж болохуйц худал, зөрүүтэй буюу гүйвуулсан мэдээ тараах, бусдыг төөрөгдүүлэх, хуурч мэхлэх;

4.1.2. Үгсэн хувалдах, харилцан тохиролцо замаар биржээр арилжаалах бүтээгдэхүүний үнийг зохиомлоор тогтоох, зах зээлийг урвуулан ашиглах зорилготой аливаа үйлдэл хийх;

4.1.3. Харилцагчийн өгсөн худалдах болон худалдан авах захиалгын нөхцлийг /захиалгын тоо ширхэг, үнэ, төрөл/ санаатай байдлаар өөрчлөн програмд оруулах;

4.1.4. Дуудлага арилжааны үнэ ханш тогтоход нөлөөлөх;

4.1.5. Дотоод мэдээлэл өзэмшигч, түүний холбогдох этгээд уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд дотоод мэдээлэл ашиглан оролцох;

4.1.6. Нийтэд болон гадаад дотоодын худалдан авагчдад хүргэх мэдээллийг нуун дарагдуулах, холбогдох этгээдэд өгөхөөс татгалзах, бусдын нэрийн өмнөөс өөрийн нэрийн данс болон захиран зарцуулах эрх бүхий бусад дансаар арилжаа, мөнгөн хөрөнгийн гүйлгээ хийх;

4.1.7. Үнэ ханшид нөлөөлөх зорилгоор зах зээлтэй холбоотой худал, буруу мэдээллийг олон нийтэд тараах;

4.1.8. Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан олон нийтийг төөрөгдөл оруулах, хуурамч мэдээлэл түгээх, амлалт өгөх, ятгах;

4.1.9. Анхан шатны баримтыг буруу, дутуу хөтлөх, хуурамчаар бүрдүүлэх;

4.1.10. Арилжаа шударга явагдах нөхцөл болон харилцагчийн эрх ашгийг зөрчсөн бусад үйлдлүүд хийх;

4.1.11. Хяналт шалгалтын мэргэжилтний албан даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй, анхан шатны болон санхүүгийн холбогдолтой баримтыг зохих журмын дагуу бүрдүүлээгүй, тайлан мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэд гаргаагүй;

4.1.12. Шалгалтын ажилд шаардлагатай баримт материал гаргаж өгөөгүй, шалгалтын ажилд саад учруулах;

4.1.13. Хууль тогтоомж, дүрэм, журам, гэрээгээр хориглосон бусад үйл ажиллагаа.

ТАВ. ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

- 5.1. Хяналт шалгалтын мэргэжилтэн нь арилжааны захиалгатай холбоотой анхан шатны баримт ирүүлэх хугацаатай албан даалгаврыг брокер болон арилжаанд оролцогчид өгнө.
- 5.2. Хяналт шалгалтын мэргэжилтэн нь шалгалт хийж дууссаны дараа тайлан бичиж, хяналт шалгалт хариуцсан нэгж, газрын удирдлага болон Биржийн гүйцэтгэх захираалд танилцуулна.
- 5.3. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил нь Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу Хорооны хянан шалгах зөрчлийн шинжтэй тохиолдолд энэ талаар Хороонд мэдэгдэнэ.
- 5.4. Зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд тооцогдохгүй боловч Хорооны болон Биржийн холбогдох журам, гэрээг зөрчсөн нь шалгалтаар тогтоогдвол энэ журмын 6 дугаар зүйлд заасан хариуцлагын арга хэмжээ авна.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Хяналт шалгалтын мэргэжилтний тайлан, зөрчлийн шинж чанарыг харгалзан арилжаанд оролцогч болон брокерт дараах хариуцлагын арга хэмжээний аль тохирохыг авна. Үүнд:
 - 6.1.1. Брокерын хувьд:
 - 6.1.1.1. Сануулах;
 - 6.1.1.2. Арилжаанд оролцох эрхийг 3 хүртэлх сараар түдгэлзүүлэх;
 - 6.1.1.3. Гишүүнчлэлээс хасах.
 - 6.1.2. Бусад оролцогчдын хувьд:
 - 6.1.2.1. Гэрээнд заасан арга хэмжээ авах;
 - 6.1.2.2. Биржтэй байгуулсан гэрээг дуусгавар болгох.
- 6.2. Энэ журмын 6.1.1.1, 6.1.1.2, 6.1.2-т заасан арга хэмжээг Биржийн гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 6.3. Брокер нь энэхүү журмын 6.1.1.1, 6.1.1.2-т заасан арга хэмжээ авсанаас хойш 6 сарын дотор зөрчлөө арилгаагүй, эсхүл эрх бүхий байгууллага, хууль хяналтын байгууллагаас санал ирүүлсэн тохиолдолд гишүүнчлэлээс хасах эсэх асуудлыг Биржийн ТУЗ-ийн хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.

ДОЛОО. БУСАД АСУУДАЛ

- 7.1. Биржээс гаргасан аливаа шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд уг этгээд нь тухайн шийдвэрийг мэдэгдсэнээс хойш хуанлийн 30 хоногийн дотор холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу гомдлоо гаргаж шийдвэрлүүлнэ.